**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 23 өдөр | Дугаар А/392 | Хэрлэн сум

Хөдөө аж ахуйн хоршоологчдын
улсын зөвлөгөөн" зохион байгуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хоршооны тухай хуулийн 43.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Хоршооны тухай хууль болон бусад хууль, төрөөс хоршооллын салбар баримталж буй бодлого, чиглэлийг таниулан хоршоологчдыг мэдээллээр хангах, сурталчлах, хоршооллын салбарын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өргөх, хоршиж хөдөлмөрөөрөө нэгдэж ажиллахын давуу талыг бодитоор сурталчлах, багаар ажиллах, шударгаар өрсөлдөх чадварыг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх зорилгоор "Хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөн" зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, Худалдаа үйлчилгээний албаны дарга |
| Гишүүд: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын боловсролын бодлого хариуцсан мэргэжилтэн |
| | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн |
| | Биеийн тамир спортын газрын дарга |
| | Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулганы дарга |
| | Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга |
| | Политехник коллежийн Захирал |
| | Хэнтий аймгийн Хөдөө аж ахуйн Хоршоологчдын холбооны Тэргүүн |

2. Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

2.Дээрх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар Үйлдвэрлэл, Худалдаа үйлчилгээний албаны дарга (Г.Оюун-Эрдэнэ)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ